



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/134/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд хот

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 70523020

Цахим хаяг: DORNOGOVI@AUDIT.COM

Цахим хаяг: Lundegmaa.ts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Агуулга

1	Аудитын тайлан	5
1.1	Оршил	5
1.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
1.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
1.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
1.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
1.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
1.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
1.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
1.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
1.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
1.11	Шилэн дансны мэдээлэл	9
1.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
1.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
2	Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.	9

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44107 Дорноговь аймаг, Сайванд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (7051) 2-23-34

ДГА-02-19 № 1-6/01
санагч _____ -ны № _____

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Санхүү хяналт, аудитын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Санхүү хяналт, аудитын албаны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Санхүү хяналт, аудитын алба нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


Санхүү хяналт, аудитын албаны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үүрэг, хариуцлага

Санхүү хяналт, аудитын алба нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга Х.Оюунтуяад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019-02-18-наас 2019-02-19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019-02-19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019-01-25-ны өдрийн 20 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь “Дотоод аудитын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Санхүүгийн хяналт шалгалт
- Дотоод аудит

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Санхүү хяналт, аудитын албаны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгөөс материаллаг байдлын түвшинг тогтооход бага гарч байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг түвшинг тогтоов.

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2018 оны нийт зардал 1,195.66 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1,195.66 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэхэд алдаа зөрчил илэрсэнгүй.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	0	0.00	

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 7 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 124,208.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 124,187.2 мянган төгрөг ба үүний 76.6 хувь буюу 95,156.9 сая төгрөг нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлын данс байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭГ ЭНЭ ТАЙЛАНГИЙН 1 ДҮГЭЭР ХЭСЭГТ ҮЗҮҮЛЭВ.

Санхүү хяналт, аудитын албаны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

3.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,187,408.80	3,984,532.80
33	АВЛАГА	210,000.00	653,279.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	189,000.00	632,279.00
335	Бусад авлага	21,000.00	21,000.00
3351	Байгууллагаас авах авлага	21,000.00	21,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,977,408.80	3,331,253.80
354	Хангамжийн материал	2,977,408.80	3,331,253.80
35410	Бичиг хэргийн материал	588,808.80	818,518.80
35420	Аж ахуйн материал	2,347,335.00	2,512,735.00
35440	Түлш, шатах тослох материал	41,265.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,367,467.13	6,267,349.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,367,467.13	6,267,349.77
392	Биет хөрөнгө	8,186,842.07	6,158,974.67
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,504,231.00	10,833,999.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,222,255.68	-8,139,271.12
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,570,106.00	8,570,106.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,665,239.25	-5,105,859.21
393	Биет бус хөрөнгө	180,625.06	108,375.10
39301	Програм хангамж	289,000.00	289,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-108,374.94	-180,624.90
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,554,875.93	10,251,882.57
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,005,394.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,005,394.00	00.00
413	Өглөг	22,005,394.00	00.00
4136	Бусад өглөг	394,500.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	57,500.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	337,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-10,450,518.07	10,251,882.57
51	Засгийн газрын хувь оролцоо	-10,450,518.07	10,251,882.57
512	Хуримтлагдсан үр дүн	-10,450,518.07	10,251,882.57
51210	Өмнөх үеийн үр дүн	-10,450,518.07	-10,450,518.07
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	20,702,400.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,554,875.93	10,251,882.57

Санхүү хяналт, аудитын албаны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.2 АУДИТ ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	135,674,200.00	140,268,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	135,674,200.00	140,208,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,998,100.00	16,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,998,100.00	16,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	105,676,100.00	124,208,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	105,676,100.00	124,208,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	118,523,897.13	119,566,299.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	115,861,315.44	119,544,852.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	115,861,315.44	119,544,852.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	86,008,062.00	89,220,226.00
210101	Үндсэн цалин	85,028,062.00	84,787,468.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	980,000.00	4,432,758.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,925,849.40	10,966,801.00
210201	Тэтгэврийн даатгал	9,925,849.40	7,149,501.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	926,130.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	753,302.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	169,820.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,968,048.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	789,883.00	1,319,548.00
210301	Гэрэл, цахилгаан	448,690.00	661,365.00
210302	Түлш, халаалт	341,193.00	658,183.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,959,740.00	5,344,060.00
210401	Бичиг хэрэг	1,354,827.00	962,210.00
210402	Тээвэр, шатахуун	3,725,835.00	3,386,245.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	879,078.00	995,605.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,660,488.00	00.00
210604	Урсгал засвар	4,660,488.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	5,664,500.00	9,351,100.00
210702	Дотоод албан томилолт	5,664,500.00	9,351,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	880,450.00	597,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	880,450.00	597,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,972,343.04	2,745,317.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200,000.00	645,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,772,343.04	2,100,117.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,662,581.69	21,447.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	562,581.69	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	562,581.69	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	21,447.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	21,447.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	17,150,302.87	20,702,400.64
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	17,150,302.87	20,702,400.64

Санхүү хяналт, аудитын албаны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	135,674,200.00	140,268,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	60,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	60,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	60,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	60,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	135,674,200.00	140,208,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,998,100.00	16,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,998,100.00	16,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	105,676,100.00	124,208,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	105,676,100.00	124,208,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	130,494,200.00	140,268,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	130,494,200.00	140,268,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	127,831,618.31	140,247,253.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	99,399,438.41	108,188,684.00
210101	Үндсэн цалин	97,072,159.41	102,644,684.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,327,279.00	5,544,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,317,798.90	12,655,016.00
210201	Тэтгэврийн даатгал	9,317,798.90	8,103,416.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	951,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	761,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	190,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,648,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	789,883.00	1,319,548.00
210301	Гэрэл, цахилгаан	448,690.00	800,548.00
210302	Түлш, халаалт	341,193.00	519,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,302,505.00	6,304,405.00
210401	Бичиг хэрэг	885,650.00	1,412,800.00
210402	Тээвэр, шатахуун	2,898,500.00	3,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,013,355.00	1,061,605.00
210404	Ном, хэвлэл	00.00	30,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	505,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,498,393.00	00.00
210604	Урсгал засвар	5,498,393.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	6,403,900.00	10,348,600.00
210702	Дотоод албан томилолт	6,403,900.00	10,348,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	426,700.00	738,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	426,700.00	618,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	693,000.00	693,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	693,000.00	693,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,662,581.69	21,447.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	562,581.69	21,447.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,180,000.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,180,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,180,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,180,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,180,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-5,180,000.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Санхүү хяналт, аудитын албаны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.4 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	-28,037,020.94	-28,037,020.94
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	-28,037,020.94	-28,037,020.94
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	30,363,946.74	30,363,946.74
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	-10,450,518.07	-10,450,518.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	-10,450,518.07	-10,450,518.07
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	20,702,400.64	20,702,400.64
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	10,251,882.57	10,251,882.57

Санхүү хяналт, аудитын албаны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5 АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00.00	00.00	124,208,700.00	124,187,253.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	00.00	124,208,700.00	124,187,253.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	00.00	124,208,700.00	124,187,253.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	00.00	95,156,900.00	95,156,900.00
210101	Үндсэн цалин	00.00	00.00	89,612,900.00	89,612,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00	5,544,000.00	5,544,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	00.00	00.00	11,418,800.00	11,418,800.00
210201	Тэтгэврийн даатгал	00.00	00.00	7,612,299.00	6,867,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	951,804.00	951,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	761,579.00	761,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	190,219.00	190,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	1,902,899.00	2,648,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	00.00	1,320,700.00	1,319,548.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	00.00	00.00	509,084.00
210302	Түлш, халаалт	00.00	00.00	1,320,700.00	810,464.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	00.00	5,698,400.00	5,697,905.00
210401	Бичиг хэрэг	00.00	00.00	1,435,800.00	1,236,300.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	00.00	3,345,200.00	3,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	00.00	917,400.00	1,061,605.00
2107	Томилолт, зочны зардал	00.00	00.00	9,475,400.00	9,351,100.00
210702	Дотоод албан томилолт	00.00	00.00	9,475,400.00	9,351,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	00.00	445,500.00	550,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	00.00	325,500.00	430,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	120,000.00	120,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	693000.00	693000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	693,000.00	693,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00	124,208,700.00	124,208,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	124,208,700.00	124,208,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	124,208,700.00	124,208,700.00